

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/239-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2023 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	15-17
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГДААГИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА Б.ГАНХУЯГ ТАНАА

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

Цагаан Эрэг II бар

Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040

E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.25 № СЭА-2023/239-НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бсдох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 2,673,009.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.5 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 0.5 хувиар хэмнэсэн байна.

### Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 84.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 5.8 хувийг тээвэр, шатахууны зардал тус тус эзэлж байна.

### Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>176,941,605.3</b>	<b>234,910,201.2</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	28,642,800.0
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	28,642,800.0
31211	Төрийн сангийн харилцах	-	28,642,800.0
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	17,602,000.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	17,602,000.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	176,941,605.3	188,665,401.2
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	90,574,748.9	102,115,918.9
35110	Тусгай зориулалттай материал	84,249,748.9	94,501,418.9
35130	Эм боох материал	6,325,000.0	7,614,500.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	79,732,151.4	75,411,082.3
35410	Бичиг хэргийн материал	3,135,290.0	3,267,340.0
35420	Аж ахуйн материал	72,367,087.3	65,605,158.2
35440	Түлш, шатах тослох материал	1,529,902.6	4,168,492.6
35460	Хүнсний материал	7.5	7.5
35470	Бусад хангамжийн материал	2,699,864.0	2,370,084.0
35600	Мал амьтад	6,634,705.0	11,138,400.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,915,251,347.3</b>	<b>1,743,688,786.4</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,915,251,347.3	1,743,688,786.4
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,691,792,247.3	1,520,229,686.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,359,309,136.3	1,359,309,136.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	(192,114,935.3)	(269,804,730.5)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	245,655,766.0	240,155,766.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(96,559,539.1)	(137,996,993.5)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	562,670,753.7	646,955,549.7
39206	Хуримтлагдсан элэгдэл	(303,927,380.6)	(420,108,238.6)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,969,642.2	84,598,742.2
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,197,996.0)	(43,866,345.3)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	60,986,800.0	60,986,800.0
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	223,459,100.0	223,459,100.0
39301	Газар	223,459,100.0	223,459,100.0
39303	Програм хангамж	1,225,000.0	1,225,000.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,225,000.0)	(1,225,000.0)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,092,192,952.5</b>	<b>1,978,598,987.6</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,092,192,952.5</b>	<b>1,978,598,987.6</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,092,192,952.5	1,978,598,987.6
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,226,962,655.5	1,226,962,655.5
51101	Өмч: - төрийн	1,226,962,655.5	1,226,962,655.5
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	20,243,690.3	(93,350,274.6)
51210	Өмнөх үеийн үр дүн	20,243,690.3	20,243,690.3
51220	Тайлант үеийн үр дүн	-	(113,593,964.9)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	844,986,606.7	844,986,606.7
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,092,192,952.5</b>	<b>1,978,598,987.6</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,847,835,204.4</b>	<b>2,946,224,281.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>207,804,978.4</b>	<b>137,832,251.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	207,804,978.4	137,832,251.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,483,023.0	39,038,975.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,141,200.0	17,407,650.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,341,823.0	9,000,525.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,640,030,226.0</b>	<b>2,808,392,030.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,591,043,500.0	2,658,009,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,591,043,500.0	2,658,009,500.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	48,986,726.0	150,382,530.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,436,726.0	11,800,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,465,170.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,550,000.0	135,117,360.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,952,827,304.7</b>	<b>3,056,002,273.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,952,827,304.7</b>	<b>3,056,002,273.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,943,032,604.7	3,027,258,893.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,218,494,500.0	2,187,295,487.4
210101	Үндсэн цалин	1,211,823,629.0	1,293,438,109.0
210102	Нэмэгдэл	1,006,670,871.0	877,850,180.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,007,197.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,719,500.0	45,993,891.2
210201	Тэтгэврийн даатгал	567,300.0	6,195,544.3
210202	Тэтгэмжийн даатгал	66,600.0	254,801.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	53,400.0	203,841.0
210204	Ажилгүйдлийн даатгал	13,200.0	50,960.0
210205	Эрүүл мэндийн даатгал	47,019,000.0	39,288,745.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	91,805,000.0	88,146,158.0
210301	Гэрэл, цахилгаан	19,086,180.0	12,837,603.0
210302	Түлш, халаалт	62,783,862.0	67,690,029.0
210303	Цэвэр, бохир ус	9,934,958.0	7,618,526.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	204,177,282.0	251,374,719.2
210401	Бичиг хэрэг	14,829,400.0	23,429,140.0
210402	Тээвэр, шатахуун	157,254,402.0	194,414,010.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,290,160.0	13,784,870.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	156,000.0	209,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,076,084.0	19,537,699.1
210408	Бараа материал акталсны зардал	5,571,236.0	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	36,324,430.0	26,307,800.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,046,180.0	-
210502	Хоол, хүнс	35,278,250.0	26,307,800.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	51,299,427.0	86,465,730.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	22,827,200.0	1,997,010.0
210604	Урсгал засвар	28,472,227.0	84,468,720.0
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	30,039,200.0	31,933,500.0
210702	Дотоод албан томиллолт	30,039,200.0	31,933,500.0

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,063,645.0	12,874,603.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,181,400.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	950,000.0	544,631.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.0	-
210807	Газрын төлбөр	-	1,818,792.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,713,645.0	329,780.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	248,109,620.7	296,867,004.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,697,325.0	27,474,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,246,619.5	8,732,520.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	240,165,676.2	260,660,484.5
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,794,700.0	28,743,380.2
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,460,000.0	12,260,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,960,000.0	12,260,000.0
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,334,700.0	16,483,380.2
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,334,700.0	16,424,020.2
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(104,992,100.3)</b>	<b>(109,777,992.6)</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	7,342,999.8	3,815,972.3
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,342,999.8	3,815,972.3
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(7,342,999.8)	(3,815,972.3)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(112,335,100.2)</b>	<b>(113,593,964.9)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,658,171,425.0</b>	<b>2,876,124,480.0</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,141,200.0</b>	<b>50,130,450.0</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,141,200.0	50,130,450.0
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	18,141,200.0	50,130,450.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,141,200.0	17,407,650.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	32,722,800.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,640,030,225.0</b>	<b>2,825,994,030.0</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,591,043,500.0	2,658,009,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,591,043,500.0	2,658,009,500.0
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	48,986,725.0	167,984,530.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,436,725.0	11,800,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,465,170.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,550,000.0	152,719,360.0
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,657,171,425.0</b>	<b>2,823,005,480.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,657,171,425.0</b>	<b>2,823,005,480.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,647,376,725.0</b>	<b>2,762,308,099.8</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,218,494,500.0	2,193,035,487.4
210101	Үндсэн цалин	1,297,372,200.0	1,297,018,109.0
210102	Нэмэгдэл	921,122,300.0	880,010,180.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,007,197.8
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,719,500.0	45,993,891.2
210205	Эрүүл мэндийн даатгал	47,719,500.0	45,993,891.2

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	91,805,000.0	88,146,158.0
210301	Гэрэл, цахилгаан	19,086,180.0	12,837,603.0
210302	Түлш, халаалт	62,783,862.0	67,690,029.0
210303	Цэвэр, бохир ус	9,934,958.0	7,618,526.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	160,412,800.0	249,701,440.1
210401	Бичиг хэрэг	13,838,540.0	22,403,800.0
210402	Тээвэр, шатахуун	126,989,200.0	205,157,770.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,669,160.0	13,784,870.1
210404	Ном, хэвлэл	120,000.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	156,000.0	209,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,639,900.0	8,146,000.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	24,455,000.0	29,027,300.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.0	1,289,500.0
210502	Хоол, хүнс	22,655,000.0	26,307,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,430,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,950,000.0	57,427,200.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,366,500.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.0	1,055,000.0
210604	Урсгал засвар	30,950,000.0	46,005,700.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	17,703,200.0	31,933,500.0
210702	Дотоод албан томилолт	17,703,200.0	31,933,500.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,350,000.0	14,662,823.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	12,299,400.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	950,000.0	544,631.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.0	-
210807	Газрын төлбөр	-	1,818,792.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	50,486,725.0	52,380,300.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,986,725.0	45,372,300.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.0	7,008,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,794,700.0</b>	<b>60,697,380.2</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,460,000.0	26,612,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.0	14,352,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,960,000.0	12,260,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,334,700.0	34,085,380.2
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,334,700.0	16,424,020.2
213304	Хөрөнгийн	-	17,661,360.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,000,000.0</b>	<b>53,119,000.0</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,000,000.0</b>	<b>24,476,200.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,000,000.0</b>	<b>24,476,200.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,000,000.0	24,476,200.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,000,000.0	24,476,200.0
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,000,000.0)</b>	<b>(24,476,200.0)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	28,642,800.0
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	28,642,800.0

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан



Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,207,738,655.49	844,986,606.74	132,578,791.47	2,185,304,053.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,207,738,655.49</b>	<b>844,986,606.74</b>	<b>132,578,791.47</b>	<b>2,185,304,053.70</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	12,432,333.44	-	-	12,432,333.44
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(112,335,100.16)	(112,335,100.16)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	20,243,690.31	2,092,192,952.54
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	20,243,690.31	2,092,192,952.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,226,962,655.49</b>	<b>844,986,606.74</b>	<b>20,243,690.31</b>	<b>2,092,192,952.54</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(113,593,964.91)	(113,593,964.91)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	(93,350,274.60)	1,978,598,987.63

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,673,009,500.0	2,658,993,129.8	14,016,370.2	99.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,673,009,500.0	2,658,993,129.8	14,016,370.2	99.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,649,037,600.0	2,636,461,129.8	12,576,470.2	99.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,193,821,900.0</b>	<b>2,193,035,487.4</b>	<b>786,412.6</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	1,292,702,300.0	1,297,018,109.0	(4,315,809.0)	100.3
210102	Нэмэгдэл	886,119,600.0	880,010,180.6	6,109,419.4	99.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,000,000.0	16,007,197.8	(1,007,197.8)	106.7
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,772,900.0</b>	<b>45,993,891.2</b>	<b>779,008.8</b>	<b>98.3</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	46,772,900.0	45,993,891.2	779,008.8	98.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>88,339,400.0</b>	<b>88,146,158.0</b>	<b>193,242.0</b>	<b>99.8</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,032,400.0	12,837,603.0	194,797.0	98.5
210302	Түлш, халаалт	67,715,700.0	67,690,029.0	25,671.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	7,591,300.0	7,618,526.0	(27,226.0)	100.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>198,726,100.0</b>	<b>198,697,270.1</b>	<b>28,829.9</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	22,403,800.0	22,403,800.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	154,414,500.0	154,413,600.0	900.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,524,900.0	13,524,870.1	29.9	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,900.0	209,000.0	27,900.0	88.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,146,000.0	8,146,000.0	-	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>21,627,300.0</b>	<b>21,627,300.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,289,500.0	1,289,500.0	-	100.0
210502	Хоол, хүнс	18,907,800.0	18,907,800.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,430,000.0	1,430,000.0	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>61,379,000.0</b>	<b>61,360,700.0</b>	<b>18,300.0</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,300,000.0	14,300,000.0	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,073,300.0	1,055,000.0	18,300.0	98.3
210604	Урсгал засвар	46,005,700.0	46,005,700.0	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,930,000.0</b>	<b>11,929,500.0</b>	<b>500.0</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	11,930,000.0	11,929,500.0	500.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,432,700.0</b>	<b>14,662,823.0</b>	<b>10,769,877.0</b>	<b>57.7</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,300,000.0	12,299,400.0	10,000,600.0	55.2

210804	Тээврийн хэрэгслийн татвар	916,700.0	544,631.0	372,069.0	59.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	386,000.0	-	386,000.0	-
210807	Газрын төлбөр	1,830,000.0	1,818,792.0	11,208.0	99.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,008,300.0</b>	<b>1,008,000.0</b>	<b>300.0</b>	<b>100.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,008,300.0	1,008,000.0	300.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,971,900.0</b>	<b>22,532,000.0</b>	<b>1,439,900.0</b>	<b>94.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,971,900.0</b>	<b>22,532,000.0</b>	<b>1,439,900.0</b>	<b>94.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,782,000.0	14,352,000.0	1,430,000.0	90.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,189,900.0	8,180,000.0	9,900.0	99.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,673,009,500.0</b>	<b>2,658,993,129.8</b>	<b>14,016,370.2</b>	<b>99.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,658,009,500.0</b>	<b>2,641,585,479.8</b>	<b>16,424,020.2</b>	<b>99.4</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,658,009,500.0	2,641,585,479.8	16,424,020.2	99.4
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>15,000,000.0</b>	<b>17,407,650.0</b>	<b>(2,407,650.0)</b>	<b>116.1</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.0	17,407,650.0	(2,407,650.0)	116.1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>152.0</b>	<b>133.0</b>	<b>19.0</b>	<b>87.5</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	147.0	130.0	17.0	88.4
620003	Үйлчлэх ажилтан	4.0	2.0	2.0	50.0


## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>167,984,530.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>167,984,530.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>150,323,170.0</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>51,004,170.0</b>
210402	Тээвэр, шатахуун	50,744,170.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	260,000.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,400,000.0</b>
210502	Хоол, хүнс	7,400,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,800,000.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,800,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,004,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	20,004,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>53,115,000.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,115,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.0
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>17,661,360.0</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	17,661,360.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>167,984,530.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>167,984,530.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,800,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,465,170.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,719,360.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар нь “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.



#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх;
- Нийгмийн хэв журам сахиулах;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Захиргааны хяналт тавих үүрэг гүйцэтгэх буюу хуулиар хүлээлгэсэн хуулийн биелэлтэд хяналт тавих.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ. Тайлант онд ЦЕГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газраас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус Цагдаагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 422 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын цагдаа, дотоод цэргийн байгууллагуудад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113,594.0 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	28,642.8	28,642.8
Авлага	-	17,602.0	17,602.0
Бараа материал	176,941.6	188,665.4	11,723.8
Үндсэн хөрөнгө	1,915,251.3	1,743,688.8	(17,562.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,092,193.0</b>	<b>1,978,599.0</b>	<b>(113,594.0)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,092,193.0	1,978,599.0	(113,594.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,092,193.0</b>	<b>1,978,599.0</b>	<b>(113,594.0)</b>

Мөнгөн хөрөнгө данс нь тайлант онд 28,642.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байгаа нь ахмадын сангийн зарцуулаагүй үлдэгдлээс шалтгаалсан байна.

Авлага данс нь тайлант онд 17,602.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байгаа нь татаас санхүүжилтийн авлагаас шалтгаалсан байна. /Ерөө сумын нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэж байгаа хамгаалалтын постуудад үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын тээвэр, шатахууны зардлын авлага/

Бараа материал дансны үлдэгдэл 188,665.4 мянган төгрөг болж 11,723.8 мянган төгрөгөөр буурсан байгаа нь төсвийн хөрөнгөөр 332,720.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, систем хоорондын шилжүүлгээр 30,355.6 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан, малын нас дэвшилт, төл малын орлого 11,138.4 мянган төгрөг болон шатахууны урамшуулал 4,496.8.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 366,987.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,616,690.1 мянган төгрөг болж 87,413.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн санхүүжилтээр 24,476.2 мянган төгрөгийн /13,999.0 мянган төгрөгийн процессор, 8,800.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэц гэх мэт/ хөрөнгө худалдан авсан, ХЗДХЯ-аас Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслөөс 68,437.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон аймгийн ОНӨГ-ын 2022 оны 63 дугаар албан бичгээр 5,500.0 мянган төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгслийг акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,978,599.0 мянган төгрөг болж 113,594.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус Цагдаагийн газар нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,895,417.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 15,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,910,417.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчаас хүргүүлсэн төсвийн төслийн саналаас цалин, хөлс нэмэгдэл, урамшууллын зардлыг 60,153.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 842.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 25,178.8 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 7,455.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 10,195.00 мянган төгрөгөөр, хангамж, эд хогшил, урсгал засварын зардлыг 4,000.0 мянган төгрөгөөр, их засварыг 185,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 2,617,592.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 55,417.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж зохицуулалт/ цалин, хөлс нэмэгдэл, урамшууллын зардлыг 15,000.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллыг 15,782.0 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь голлон нөлөөлсөн/ хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,658,009.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 15,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,658,009.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 17,407.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,658,993.1 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын зардлыг 1,565.4 мянган төгрөгөөр, бусдаар

гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 10,769.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,639,037.6	2,636,461.1	2,576.5	99.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	23,971.9	22,352.0	1,439.9	93.2
3	Байцаан шийтгэх ажиллагааны зардал	10,000.0	-	10,000.0	-
	<b>Нийт</b>	<b>2,673,009.5</b>	<b>2,658,993.1</b>	<b>14,016.4</b>	<b>99.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 167,984 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- ЦЕГ-аас 2022 оны 2 дугаар улиралд орон нутгийн нөхөн сонгуулийн зардалд 2,220 мянган төгрөг,
- Сүхбаатар сумын ЗДТГ-аас сумын наадмын хамгаалалтын зардалд 1,000.0 сая төгрөг,
- Аймгийн БОАЖГ-аас сэтгэцэд нөлөөлөх хорт ургамлын устгалын зардалд 20,000.0 сая төгрөг,
- Аймгийн ЗДТГ-аас баяр наадмын хамгаалалтын зардал, алсын дуудлагын автомашины засвар болон техник хэрэгсэл худалдан авах зардалд нийт 27,382.1 мянган төгрөг,
- Ерөө сумын ЗДТГ-аас хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгаалалтын постны зардалд 70,000.0 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сүлжээний засвар үйлчилгээ, техник хэрэгслийн зардалд 10,000.0 мянган төгрөг,
- Иргэдэд галт зэвсэг эзэмшүүлэх чадамж олгох сургалтын төлбөрт 14,106.0 мянган төгрөг, Дархан-Уул аймгийн Цагдаагийн газраас бүсчилсэн сургалтын зардалд 1,245.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 2,419.2 мянган төгрөгийн орлого.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.



Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 44/1-388 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,952,827.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 29,528.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны даргын 2022 оны 6/947 дугаар “Ажлын чиглэл хүргүүлэх тухай”- албан бичгийн дагуу дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэхээс бусад чиглэлээр хөдөө, орон нутагт томилолтоор ажиллахыг зогсоосон,
- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Тээвэр шатахуун, хичээл сургалт үйлдвэрлэлийн зардлыг хэмнэх зорилгоор 2 удаагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан,

- Баяр ёслол, тэмдэглэлт өдөр, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой контент, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй.
- Ээлжийн амралтаар орон нутагт явах зардлыг олгоогүй ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалтыг зөрчиж ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 14/1772 дугаар албан бичгийн 8 дугаарт "Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон "Ахмадын сан"-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах" гэж үүрэг чиглэлийг өгсний дагуу бичиг хэргийн зардлын хэмнэлт болох 9,020.0 мянган төгрөгөөр бичгийн цаас, принтерийн хор, баримтын хавтас зэрэг хэрэгцээнээс илүү бараа материал худалдан авч нөөцөлсөн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт


##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар НБББББ-ийг шинэчлэх, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой нийт 16,543.6 мянган төгрөгийн 3 зөрчилд

зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжих 2 зөвлөмж нь хэрэгжээгүй байна.



Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	16,543.6	1	8,900.0	53.8
Нийт дүн	3	16,543.6	1	8,900.0	53.8

Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрийн дагуу хэрэгжээгүй 2 зөвлөмжийг тус дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулахаар шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. ЦЕГ-аас “Киа моторс-Монгол” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2021 онд үйлдвэрлэж, орж ирсэн KIA RIO суудлын автомашиныг 2021 оны 8 дугаар сард, KIA Carnival суудлын автомашиныг 2022 оны 4 дүгээр сард хүлээн авсан бөгөөд ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанаас “*Автомашин нийлүүлэх санхүүгийн түрээсийн гэрээ*”-ний дагуу төлбөрийг бүрэн төлж дуусаагүй учир автомашин нь улсын бүртгэлд нийлүүлэгч байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байна.

2. Ажлын үр дүнгээр сахилгын шийтгэл ногдуулж, албан тушаалын үндсэн цалинг тодорхой хувиар бууруулсан 34 албан хаагчийн суутгалыг хийхдээ **үндсэн цалинг бууруулах бус** цалингийн цэсийн нэмэгдэл талд хасах утгаар оруулж тооцсон байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт болон аймгийн Цагдаагийн газрын холбогдох тушаалуудыг тус тус зөрчсөн байна.

3. Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль эрхийн актын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах шаардлагатай байна.

4. ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 14/1772 дугаар албан бичгийн 8 дугаарт "Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон "Ахмадын сан"-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах" гэж үүрэг чиглэл өгсний дагуу цалингийн сангийн хэмнэлт 5,740.0 мянган төгрөгийг "Ахмадын сан"-гийн дансанд шилжүүлж, бичиг хэргийн зардлын хэмнэлт болох 9,020.0 мянган төгрөгөөр бичгийн цаас, принтерийн хор, баримтын хавтас зэрэг хэрэгцээнээс илүү бараа материал худалдан авч нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7 дахь "...Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд .... төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.6: "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5. ЦЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/336 дугаар тушаалын дагуу нэг удаагийн тэтгэмж, урамшууллын хэмнэгдсэн зардлаас 14,352.0 мянган төгрөг болон Санхүү, аж ахуйн албаны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 14/1772 дугаар албан бичгийн дагуу цалингийн хэмнэлт 5,740.0 мянган төгрөг зэрэг нийт тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 20,092.0 мянган төгрөгийг "Ахмадын сан"-ийн дансанд шилжүүлсэн байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд дээрх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үндсэн хөрөнгийн шинж чанартай 7,242.8 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн болон 2 үндсэн хөрөнгөд 3,729.3 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй зэрэг нийт 10,972.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар илэрсэн 22,229.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн 4,147.3 мянган төгрөгийн дараах ажил, гүйлгээнүүдийг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Холбогдох албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлээгүй 17 албан хаагчид **3,199.0** мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон,
- Авто машиныг ашигласан албан тушаалтан, явсан хоног хугацаа тодорхой бус жолоочийн тооцооны хуудсаар **948.3** мянган төгрөгийн шатахуун зарцуулсан,
- Бараа материалыг хүлээн авсан албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулаагүй баримтаар зарлагын ажил гүйлгээг гүйцэтгэсэн.

**1.2. Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

**2.1 Илрүүлэлт:** Тайлант онд нийт **18,082.0** мянган төгрөгийн хүнс, урсгал засварын материалын худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “ ... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	1	7,242.8			1	7,242.8	1	7,242.8				
Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцоогүй	1	3,729.3	1	3,729.3			1	3,729.3				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>10,972.1</b>	<b>1</b>	<b>3,729.3</b>	<b>1</b>	<b>7,242.8</b>	<b>2</b>	<b>10,972.1</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	4,147.3					1	4,147.3				
Төлбөрийн цахим баримтыг бөөн дүнгээр баталгаажуулсан.	1	18,082.0					1	18,082.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>22,229.3</b>	-	-	-	-	<b>2</b>	<b>22,229.3</b>				